



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 1/28

Хараат

Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 18 дугаар зүйлийн 18.4 заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Замын улаан багийн нутаг "Ланс" гэдэг газарт 2023 оны 04 дугаар сарын 17-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 14 хоногийн хугацаатайгаар тогтоосон хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2.Малчдыг мэдээллээр хангаж тухайн бүс нутаг дэвсгэрийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, малын гоц халдварт мялзан өвчнөөс сэрэмжлэх талаар гарын авлага, мэдээ мэдээллийг цахимаар олон нийтэд хүргэх, малчдад мэдээлэл өгөхийг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт болон Мал эмнэлгийн тасгийн дарга (Т.Өлзийбат)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  АЭРДЭНЭСАЙХАН

